



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 21

Мандалговь

Орон тооны бус Хяналтын зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.9, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтолын хавсралтаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмын 3 дугаар зүйлийн 3.2 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Хяналтын зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

А. Зөвлөлийн дарга : Ж. Мөнхтөр (ИТХ-ын тэргүүлэгч)

Б. Нарийн бичгийн дарга : С. Отгонбямба (Санхүү албаны дарга)

В. Гишүүд : Д. Отгонсүрэн (ИТХ-ын тэргүүлэгч)

1-р багийн төлөөлөл Д. Алтантогос

2-р багийн төлөөлөл У. Эрдэнэцэцэг

3-р багийн төлөөлөл Ж. Мөнхзул

4-р багийн төлөөлөл Ц. Цогзолмаа

5-р багийн төлөөлөл Ө. Адъяасүрэн

6-р багийн төлөөлөл Б. Насанбаяр

7-р багийн төлөөлөл Д. Мөнхцоож

8-р багийн төлөөлөл М. Билгүүн

9-р багийн төлөөлөл Д. Тунгалаг

2. Сум хөгжүүлэх сангийн зээлийг чиглэлийн дагуу олгож байгаа эсэхэд хяналт тавьж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллахыг Хяналтын зөвлөлд даалгасугай.

3. Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж дүнг Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Хяналтын зөвлөлийн дарга (Ж. Мөнхтөр)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Т. БАТЖАРГАЛ

D:/ITKHural/Terguulegch. togtool.03.25